



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2024 оны 11 сарын 14 өдөр

Дугаар A/06

Улаанбаатар хот

Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
хорооны бүрэлдэхүүн, даргыг сонгох,
ажиллах журмыг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.3 дэх заалт, 39 дүгээр зүйлийн 39.1.2, 39.3 дэх хэсэг, 45 дугаар зүйл, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсгийг тус тус үндэслэн нийслэлийн Багахангай дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит II хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг урьдчилан бэлтгэх, санал дүгнэлт гаргах, Хурлын тогтоол, шийдвэрийн биелэлтийг хянан шалгах чиг үүрэг бүхий Хурлын хороог 5 байхаар тогтоосугай.

2. Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Эрх зүй, төрийн байгуулалтын хорооны бүрэлдэхүүн, үйл ажиллагааны чиглэлийг нэгдүгээр, Төсөв, санхүү, эдийн засгийн хорооны бүрэлдэхүүн, үйл ажиллагааны чиглэлийг хоёрдугаар, Нийгмийн бодлогын хорооны бүрэлдэхүүн, үйл ажиллагааны чиглэлийг гуравдугаар, Дэд бүтэц, хот байгуулалтын хорооны бүрэлдэхүүн, үйл ажиллагааны чиглэлийг дөрөвдүгээр, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн хорооны бүрэлдэхүүн, үйл ажиллагааны чиглэлийг тавдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

3. Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хорооны ажиллах журмыг зургаадугаар хавсралтаар баталсугай.

4. Батлагдсан журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Хурлын хороодод үүрэг болгосугай.

5. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга (М.Давааням)-д даалгасугай.

6. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн A/09 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Ф.МӨНХГЭРЭЛ



E:\2024 он\Хэвлэмэл хуудас\Тогтоол A.docx

1123100069

Нийслэлийн Багахангай дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 1106 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт



Эрх зүй, төрийн байгуулалтын хорооны бүрэлдэхүүн


Хорооны дарга: Д.Баттөр

Хорооны гишүүд: Ф.Мөнхгэрэл
А.Сүхболд
Б.Болормаа
Х.Цогцэцэг
Ш.Бямбаа
О.Солонго
М.Энхболд
С.Ханддорж

Эрх зүй, төрийн байгуулалтын хорооны үйл ажиллагааны чиглэл

1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг дүүргийн хэмжээнд хангуулах, хяналт тавих
2. Орон нутгийн хөгжлийн бодлого төлөвлөлтийг тодорхойлох
3. Дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих
4. Дүүргийн гадаад, дотоод харилцаа, хамтын ажиллагаа
5. Газрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, ерөнхий ба хэсэгчилсэн төлөвлөгөөний төслийг хэлэлцэх
6. Дүүргийн нутагт дэвсгэрт Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, холбогдох байгууллагуудтай хамтарч ажиллах
7. Гамшгаас хамгаалах чиглэлээр хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, холбогдох байгууллагуудтай хамтарч ажиллах
8. Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах
9. Иргэдийг мэдээ мэдээллээр хангах, төрийн байгууллагуудын үйл ажиллагааны ил тод байдлыг хангуулж, цахимжуулах
10. Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хуралдаанаар тухайн хороонд хамаарах хэлэлцэх асуудлыг урьдчилан бэлтгэх, санал дүгнэлт гаргах
11. Хорооны чиг үүрэгт хамаарах Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаатай танилцах, арга зүйн удирдлагаар хангах, заавар зөвлөмж өгөх
12. Иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэх

Нийслэлийн Багахангай дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Төлөөлөгчдийн хорооны 11 дүгээр сарын 14-ний
өдрийн 1106 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт



Төсөв, санхүү, эдийн засгийн хорооны бүрэлдэхүүн

Хорооны дарга: Б.Болормаа

Хорооны гишүүд:
Ф.Мөнхгэрэл
М.Цогт
Б.Гэрэлмаа
М.Өсөхдэлгэр
Ш.Бямбаа
Ж.Батбаатар
Д.Жүгдэр
О.Солонго

Төсөв, санхүү, эдийн засгийн хорооны үйл ажиллагааны чиглэл

1. Эдийн засаг, төсөв санхүүгийн талаарх хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг дүүргийн хэмжээнд хангуулах, хяналт тавих
2. Дүүргийн төсвийн орлогын бүрдүүлэлт, гүйцэтгэлд хяналт тавьж, төсвийн ил тод байдлыг хангах, орлогын шинэ эх үүсвэр бий болгох арга замуудыг судалж шийдвэрлүүлэх, хяналт тавих
3. Дүүрэг, орон нутагт хэрэгжиж буй хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэлийн явцад иргэдийн оролцоотой хяналт тавих
4. Дүүргийн гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг дэмжих бодлогыг хэрэгжүүлэх
5. Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлт, хуваарилалт болон бусад сангийн бүрдүүлэлт, зарцуулалтад хяналт тавих
6. Дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих
7. Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, захиран зарцуулалтад тавих хяналтыг зохион байгуулах, авах арга хэмжээг тодорхойлж, санал дүгнэлт гаргах хэрэгжилтэд хяналт тавих
8. Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хуралдаанаар тухайн хороонд хамаарах хэлэлцэх асуудлыг урьдчилан бэлтгэх, санал дүгнэлт гаргах
9. Хорооны чиг үүрэгт хамаарах Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаатай танилцах, арга зүйн удирдлагаар хангах, заавар зөвлөмж өгөх

Нийслэлийн Багахангай дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Төлөөлөгчдийн 2024 оны 11 дүгээр сарын 14-ний
өдрийн 4/06 дугаар тогтоолын гуравдугаар хавсралт



Нийгмийн бодлогын хорооны бүрэлдэхүүн

Хорооны дарга: Б.Бат-Эрдэнэ

Хорооны гишүүд:
Х.Цогцэцэг
Г.Дагвадорж
Л.Өлзийжаргал
Д.Жүгдэр
Б.Батзориг
Н.Нямзав
Т.Гэлэгдорж
Б.Раднааханд

Нийгмийн бодлогын хорооны үйл ажиллагааны чиглэл

1. Нийгмийн салбарын хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг дүүргийн хэмжээнд хангуулах, хяналт тавих
2. Улс, нийслэлээс хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих
3. Дүүргийн иргэдийн боловсрол, эрүүл мэнд, хүүхэд, залуучууд, гэр бүл, нийгмийн халамж үйлчилгээ, нийгмийн даатгал, соёл урлаг, биеийн тамир, спортын салбарыг хөгжүүлэх чиглэлээр холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтарч ажиллах, дэмжлэг үзүүлж мэргэжил арга зүйн удирдлагаар хангах
4. Дүүргийн хүн амын хөдөлмөр эрхлэлт, ажлын байрыг нэмэгдүүлэх замаар өрхийн орлого, амьжиргааны түвшинг дээшлүүлэх
5. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах бодлогын хэрэгжилтэд хяналт тавих
6. Дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих
7. Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хуралдаанаар тухайн хороонд хамаарах хэлэлцэх асуудлыг урьдчилан бэлтгэх, санал дүгнэлт гаргах
8. Хорооны чиг үүрэгт хамаарах Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаатай танилцах, арга зүйн удирдлагаар хангах, заавар зөвлөмж өгөх



Хот байгуулалт, дэд бүтцийн хорооны бүрэлдэхүүн

Хорооны дарга: Д.Цэвэгдорж

Хорооны гишүүд: Г.Дагвадорж
М.Цогт
Д.Гантулга
Ж.Батбаатар
Б.Бат-Эрдэнэ
Б.Батзориг
Т.Гэлэгдорж
Б.Раднааханд

Хот байгуулалт, дэд бүтцийн хорооны үйл ажиллагааны чиглэл

1. Хот байгуулалт, дэд бүтцийн салбарын хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг дүүргийн хэмжээнд хангуулах, хяналт тавих
2. “Багахангай 2040 хөгжлийн хөтөлбөр” бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт тавих
3. Дэд бүтэц, хот тохижилт, зам харилцаа, нийтийн тээвэр, гэрэлтүүлэг чимэглэл, хаягжилт, амьдрах орчны эрүүл, аюулгүй байдлыг хангахад санал дүгнэлт гаргах, хэрэгжилтэд хяналт тавих.
4. Дулаан, цахилгаан, холбоо, орон сууц, сууц өмчлөгчдийн холбооны үйл ажиллагаа, цэвэр усны хангамжийн талаар санал дүгнэлт гаргах
5. Дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих
6. Дүүргийн дэд бүтцийн байгууллагуудтай хамтарч ажиллах, дэмжлэг үзүүлэх мэргэжил арга зүйн удирдлагаар хангах
7. Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хуралдаанаар тухайн хороонд хамаарах хэлэлцэх асуудлыг урьдчилан бэлтгэх, санал дүгнэлт гаргах
8. Хорооны чиг үүрэгт хамаарах Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаатай танилцах, арга зүйн удирдлагаар хангах, заавар зөвлөмж өгөх

Нийслэлийн Багахангай дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Төлөөлөгчдийн 2021 оны 11 дүгээр сарын 11-ний
өдрийн 11 дугаар тогтоолын тавдугаар хавсралт



Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн хорооны бүрэлдэхүүн

Хорооны дарга: Д.Ууганбаатар

Хорооны гишүүд:
А.Сүхболд
Л.Өлзийжаргал
Б.Гэрэлмаа
М.Өсөхдэлгэр
М.Энхболд
Д.Цэвэгдорж
Д.Мягмарцэнд
С.Ханддорж

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн хорооны үйл ажиллагааны чиглэл

1. Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн салбарын хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг дүүргийн хэмжээнд хангуулах, хяналт тавих
2. Дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих
3. Хүрээлэн буй орчин, ус, хөрс, агаарын бохирдол, хог хаягдлын менежментийн удирдлагыг хэрэгжүүлэх
4. Байгаль экологийн тэнцвэрт байдал, байгаль орчныг хамгаалахад чиглэсэн санал дүгнэлт гаргах, хэрэгжилтэд хяналт тавих
5. Ногоон байгууламж, эко орчныг нэмэгдүүлэх чиглэлээр олон талт арга хэмжээ авч, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд ажиллаж амьдрах нөхцөл боломжийг бүрдүүлэх, хэрэгжилтэд нь хяналт тавих
6. Хувийн хэвшил, технологийн шинэчлэлд тулгуурласан жижиг дунд үйлдвэр, эрчимжсэн хөдөө аж ахуйг дэмжсэн бодлогыг хэрэгжүүлэх
7. Улс, нийслэлийн хэмжээнд хэрэгжүүлж буй хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн салбарын төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулах
8. Бэлчээрийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулах талаар
9. холбогдох байгууллагуудтай хамтарч ажиллах
10. Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хуралдаанаар тухайн хороонд хамаарах хэлэлцэх асуудлыг урьдчилан бэлтгэх, санал дүгнэлт гаргах
11. Хорооны чиг үүрэгт хамаарах Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаатай танилцах, арга зүйн удирдлагаар хангах, заавар зөвлөмж өгөх

Нийслэлийн Багахангай дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчдийн Хорооны 2024 дүгээр сарын 14-ний өдрийн 4/06 дугаар тогтоолын зургаадугаар хавсралт



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ХОРООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

Нэг. Журмын зорилго

1.1.Багахангай дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал (цаашид “Хурал” гэх)-ын хорооны үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.

1.2.Хороо нь Хурлын тасралтгүй, байнгын үйл ажиллагааг хангаж, хуралдаанаар хэлэлцэх асуудлыг урьдчилан хэлэлцэж, санал, дүгнэлт гаргах, Хурлын тогтоол, шийдвэрийн биелэлтэд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Хоёр.Хурлын хороо байгуулах, бүрэлдэхүүн, даргыг сонгох

2.1.Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар Хурлын хороог энэхүү журмын 2.3 дахь хэсэг болон орон нутгийн онцлогийг харгалзан байгуулна.

2.2.Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчдөөс урьдчилан санал авсны дагуу Хурлын бүрэн эрхийн хугацаанд ажиллах хороо, үйл ажиллагааны журмыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргаас санал оруулан хэлэлцүүлж батлуулна.

2.3.Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчдөөс урьдчилан санал авч, Хурлын даргаас танилцуулсан саналыг хуралдаанаар хэлэлцэн олонхын саналаар хорооны бүрэлдэхүүнийг батална.

2.4.Хурлын хорооны даргыг тухайн хорооны гишүүд дотроосоо олонхын саналаар сонгоно.

Гурав.Хурлын хороодын бүтэц

3.1.Хурал нь өөрийн нутаг дэвсгэр, хүн амын тоо газар зүйн байршил, нийгэм, эдийн засгийн хөгжлийн онцлог, төлөөлөгчдийн тоог харгалзан хороог 7-9 гишүүнтэйгээр сонгож байгуулна. Хорооны нэр, бүтэц бүрэлдэхүүн, түүнд өөрчлөлт оруулах асуудлыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар шийдвэрлэнэ.

3.2.Хурал нь хариуцах ажлын онцлог, хэмжээ далайц, цаг үеийн хэрэгцээ шаардлагыг харгалзан хороодын харьяанд дэд хороо, ажлын хэсгийг байгуулан ажиллуулж болно.

3.3.Хурал нь дараах нэр бүхий хороог байгуулж ажиллуулна:

- 3.3.1.Эрх зүй, төрийн байгуулалтын хороо;
- 3.3.2.Төсөв, санхүү эдийн засгийн хороо;
- 3.3.3.Нийгмийн бодлогын хороо;
- 3.3.4.Хот байгуулалт, дэд бүтцийн хороо;
- 3.3.5.Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн хороо

3.4.Орон нутгийн хөгжлийн бодлого, чиглэл, цаг үеийн шаардлага, гаргасан шийдвэрийн хэрэгжилт, иргэдийн эрэлт хүсэлтийг үндэслэн ажлын хэсэг байгуулан ажиллуулж болно.

3.5.Хороодод хариуцсан ажлын чиглэлээр дүүргийн аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус байгууллага, Засаг даргын Тамгын газар, түүний дэргэдэх газар хэлтэс, албадыг хуваарилан ажиллуулна.

3.6.Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэд Ёс зүйн дэд хороо ажиллана.

3.7.Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэдэх Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүн нь 5-7 гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд бүрэлдэхүүнд иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дахь нам, эвслийн болон бие даагчийн төлөөллийг оролцуулан сонгоно.

3.8.Хорооны хуралдааныг хорооны дарга удирдаж, гишүүддээ ажил үүрэг хуваарилж, үйл ажиллагааг үнэлж дүгнэн, хуралдаанд ажлаа тайлагнана.

3.9.Хурлын хорооны дарга хуралдааны тэмдэглэл, албан бичигт гарын үсэг зурж баталгаажуулна.

Дөрөв.Хурлын хороодын үйл ажиллагааны чиглэл

4.1.Хурлын хороод нь Хурлын хуралдаанаар хэлэлцэх асуудлыг бэлтгэх, судлах, санал, дүгнэлт гаргах асуудлаар хорооны гишүүд, дэд хороодыг оролцуулж хуваарь гарган ажиллуулж дүн, мэдээллийг хорооны хурлаар хэлэлцэж санал, дүгнэлтээ нэгтгэнэ.

4.2.Байгууллага, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага, холбогдох иргэдийн Нийтийн Хурал, иргэд, сонгогчид, судлаачдын санал бодлыг судалж санал, дүгнэлтийг боловсруулна.

4.3.Хурлын хуралдаанаар хэлэлцэх асуудлаар болон гаргасан шийдвэрийн талаар иргэдэд мэдээлэл өгөх, өдөрлөг, уулзалт, ярилцлага, хэлэлцүүлэг зохион байгуулах, нээлттэй сонсгол хийх зэрэг олон нийтэд зориулсан арга хэмжээг зохион байгуулж ажиллана.

4.4.Хурлын хорооны гишүүдийг эрхэлсэн ажил, мэргэжил, туршлага, хүсэл сонирхлыг харгалзан гурваас доошгүй хороо, дэд хороонд нэгтгэн ажиллуулна.

4.5.Хурлын хуралдаанаас гаргасан шийдвэр болон төлөөлөгчдөөс гаргасан санал, дүгнэлтийн мөрөөр хяналт-шинжилгээ хийж, үнэлэлт дүгнэлт гарган, шаардагдах тогтоол, журамд нэмэлт, өөрчлөлт оруулах саналын хамт хорооны болон иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанд тухай бүр хэлэлцүүлж ажиллана.

4.6.Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн болон тухайн жилийн төлөвлөгөөний биелэлт, төсөв, орон нутгийн хөгжлийн сангийн гүйцэтгэл, хандивын хөрөнгийн зарцуулалтад хяналт-шинжилгээ хийж үнэлэлт, дүгнэлт гарган Хурлын хуралдаанд танилцуулна.

4.7.Хурлын хороод нь шийдвэрийн төсөл боловсруулах, биелэлт, үр дүнг дүгнэхдээ иргэд, сонгогчид, байгууллага, хамт олон, иргэний нийгмийн байгууллагуудын санал авах, үнэлгээ хийлгэх, сэтгэл ханамжийн судалгаа авах ажлыг зохион байгуулна.

4.8.Орон нутгийн хэмжээний зарим асуудлаар иргэд, иргэний нийгмийн байгууллагын саналыг үндэслэн Хурлын болон хорооны хуралдаанаар хэлэлцүүлэхээр санал боловсруулж өргөн мэдүүлнэ.

4.9.Хурлын хороо нь нутгийн удирдлагын болон төрийн үйлчилгээний байгууллага, албан тушаалтанд асуулга тавих, асуулгын биелэлт, үр дүнгийн мөрөөр хийх ажилд хяналт тавьж ажиллана.

4.10.Хурлын хуралдаанаас гаргах шийдвэрийн төсөлд Хороо, дэд хорооноос гаргасан саналыг тусгах талаар санал хурааж шийдвэрлүүлнэ.

4.11.Хурлын хороо нь хуралдаанаар хэлэлцэх асуудал болон гаргасан шийдвэр, тавьсан зорилтын биелэлтийг дүгнэхдээ судалгаа, мэдээллийг харьцуулж жиших, учир шалтгааныг судлан үзэж, холбогдох хууль тогтоомжтой нийцүүлж, явц үр дүнгийн талаар иргэдийн сэтгэл ханамжийг судалсны үндсэн дээр санал, дүгнэлт гаргана.

Тав.Хурлын хорооны үйл ажиллагааны зохион байгуулалт

5.1.Хурлын хороо нь ажлаа жилээр төлөвлөж, хагас жил тутам тайлагнаж, Хурлын хуралдаанаар хэлэлцүүлнэ.

5.2.Хурлын хорооны үйл ажиллагааны зохион байгуулалтын үндсэн хэлбэр нь хуралдаан байна.

5.3.Хурлын хорооны хуралдааныг улирал тутам болон шаардлагатай тохиолдолд тухай бүр хуралдуулж асуудлаа хэлэлцэж шийдвэрлэнэ. Хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлаар бэлтгэсэн бичиг баримтаа гишүүддээ 3-аас доошгүй хоногийн өмнө хүргүүлсэн байна. Хорооны хурлыг Хорооны дарга зарлаж хуралдаанаа удирдана. Хорооны даргын эзгүйд түүний томилсон аль нэг гишүүн хорооны хурлыг удирдана.

5.4.Хурлын хорооны хуралдаан хорооны гишүүдийн гуравны хоёроос доошгүй хувийн бүрэлдэхүүнтэйгээр хуралдаж асуудлыг ердийн олонхоор шийднэ. Хорооны ажилд гишүүн бүр идэвх, санаачилгатай, ажил хэрэгч байдлаар оролцох үүрэгтэй.

5.5.Хурлын хорооны хурлын тэмдэглэлийг тухай бүр хөтлөх бөгөөд санал, дүгнэлт гаргах, асуулга тавих, хуралдаанд болон хорооны хуралд оруулсан асуудал, албан тушаалтанд өгсөн албан бичиг, зөвлөмж, түүний хариу авсан судалгаа мэдээлэл, өргөдөл хүсэлт, түүний дагуу хийсэн ажил зэрэг нь хорооны ажлын үндсэн бичиг баримт байна.

5.6.Хурлын хорооноос Засаг дарга, түүний харьяа байгууллага, аж ахуйн нэгжид өгөх албан бичиг, саналаа иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Ажлын албаны дарга нарт танилцуулж хэвлэмэл хуудас, тамгыг хэрэглэнэ.

5.7.Хурлын хороо нь хариуцсан ажлынхаа чиглэлээр эрдэмтэн судлаачид, мэргэжилтнүүд, төрийн бус байгууллагын төлөөллөөс бүрдсэн ажлын хэсэг байгуулах саналаа тухайн шатны ИТХ-ын хуралдаанд шийдвэрлүүлнэ.

5.8.Хурлын хороо нь хэлэлцсэн асуудлаар санал дүгнэлт гаргана.

5.9.Хурлын хороо нь хийсэн ажил, гишүүдийн оролцооны байдлаа хагас жил тутам иргэд, олон нийтэд танилцуулж байна.

5.10.Хурлын хороо нь бичиг баримт, судалгаа, дүгнэлт, тайлангаа жилээр нэгтгэн ИТХ-ын ажлын албанд хүлээлгэн өгнө.

Зургаа.Хурлын хорооны даргын чиг үүрэг

6.1.Хурлын хорооны дарга дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

6.1.1.хорооны үйл ажиллагааны төлөвлөгөөг холбогдох байгууллага, албан тушаалтныг оролцуулан боловсруулна;

6.1.2.хурлын хорооны хурлын бэлтгэлийг хангаж, зохион байгуулж хуралдуулна;

6.1.3.хурлын хорооны хуралдааныг удирдана;

6.1.4.хурлын хорооны нэрийн өмнөөс бусад байгууллагатай харилцана;

6.1.5.хурлын хорооны ажлыг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын өмнө хариуцан тайлагнана.

Долоо.Хурлын хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, өөрчлөх, татан буулгах

7.1.ИТХ-ын дарга, Хурлын Зөвлөлөөс хорооны үйл ажиллагааны зардлын төсвийг жил бүрийн төсөвт тусгаж санхүүжүүлэх ба бусад шаардлагатай дэмжлэг туслалцааг үзүүлнэ. Хорооны санхүүжилтийн тайланг хууль журмын дагуу гаргах үүргийг хорооны дарга хүлээнэ.

7.2.ИТХ-ын Ажлын албаны ажилтнуудад хороог хариуцуулан хурлын бэлтгэл хангах, гишүүдэд зар мэдээ хүргэх, бичиг хэрэг, архив бүрдүүлэх, шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах ажлыг хариуцуулан туслуулна.

7.3.Хурлын хороо, дэд хорооны ажлын тайланг ИТХ-ын хуралдаанаар хагас жил тутам хэлэлцэж үнэлгээ дүгнэлт өгнө.

7.4.Хурлын хороо, түүний гишүүдийн ажлын сайн туршлага, санаачилгыг төв, орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, нийтэд сурталчлах ажлыг ИТХ-ын ажлын алба хариуцаж ажиллана.

7.5.Цаг үеийн асуудлыг судлах, санал дүгнэлт боловсруулах, хянан шалгах үүрэг бүхий дэд хороог байгуулан ажиллуулсан зорилго, хэрэгцээ, шаардлага биелсэн гэж үзвэл тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар тухайн дэд хороог өөрчлөх, татан буулгах тогтоол гаргана.

Найм.Бусад

8.1.Хурлын хорооноос өгсөн зөвлөмжийн биелэлт, албан бичгээр шаардсан мэдээ, судалгааг тогтоосон цаг хугацаанд нь гаргаж мэдээлж байх үүргийг Засаг даргын Тамгын газар, холбогдох байгууллага, аж ахуйн нэгжийн удирдлага хүлээнэ.

8.2.Хариуцсан ажлынхаа чиглэлээр Хорооны дарга, гишүүдээс байгууллага, хамт олны ажилтай танилцах, хүмүүстэй уулзаж ярилцах, сэтгэл ханамжийн болон бусад судалгаа авах ажлыг зохион байгуулж, оролцуулах үүргийг тухайн байгууллага, аж ахуйн нэгжийн удирдлага хариуцна.

8.3.Хурлын хорооноос хийсэн ажлаа сурталчлахад нь нутаг дэвсгэрийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг хэвлэл мэдээллийн байгууллага туслах, хамтарч ажиллах үүрэг хүлээнэ.

8.4.Энэхүү журамд шаардлагатай гэж үзвэл ИТХ-ын хуралдаанаар нэмэлт, өөрчлөлт оруулж болно.